

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/79/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр

2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Ахлах аудитор: С.Шийлэгмаа

Утас: 70323833 Цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.08 № 100
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Өвөрхангай - Мал эмнэлэг		СТ-1А	
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	230409515.04	1204801165.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	7013416.00	0.00
33200	Төлбөргэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7013416.00	0.00
33400	Зээлийн хүүгийн авлага		
33401	Дансны авлага /ТӨҮГ/		
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	0.00	0.00
336	Зээлийн авлага	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	223396099.04	1204801165.23
351	Түүхий эд материал	141565731.60	316054377.11
35110	Тусгай зориулалттай материал	29026331.70	36985330.08
35130	Эм боох материал	112539399.90	279069047.03
354	Хангамжийн материал	81830367.44	888746788.12
35410	Бичиг хэргийн материал	8670775.00	9280075.00
35420	Аж ахуйн материал	43710818.44	46392990.44
35430	Сэлбэг хэрэгсэл	1252800.00	1394800.00
35440	Түлш, шатах тослох материал	10838486.00	17681029.97
35450	Барилгын засварын материал	1754600.00	96200.00
35460	Хүнсний материал	58300.00	233083.10
35470	Бусад хангамжийн материал	15544588.00	813668609.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	437628458.83	443012886.03
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	437628458.83	443012886.03
391	Газар		
392	Биет хөрөнгө	436895125.49	442405266.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	126062745.50	169016161.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19488545.24	-22507127.67
39203	Авто-тээврийн хэрэгсэл	356658038.00	362504038.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-219023922.48	-238838593.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	531422494.23	312343874.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	-384772177.29	-181986796.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42602064.25	42586326.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9552155.48	-13699198.76
39216	Дуусаагүй барилга, байгууламж	12986584.00	12986584.00
393	Биет бус хөрөнгө	733333.34	607619.06
39301	Програм хангамж	880000.00	880000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-146666.66	-272380.94
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	668037973.87	1647814051.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	108920.13	113397.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	108920.13	113397.47
413	Өглөг	108920.13	113397.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	108920.13	113397.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	667929053.74	1647700653.79
51	Засгийн газрын хувь оролцоо	667929053.74	1647700653.79
512	Хуримтлагдсан үр дүн	635988572.19	1615760172.24
51210	Өмнөх үеийн үр дүн	456090079.04	635988572.19
51220	Тайлант үеийн үр дүн	179898493.15	979771600.05
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	31940481.55	31940481.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	668037973.87	1647814051.26

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Өвөрхангай - Мал эмнэлэг (РД: 3565351)			
САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			
2021 оны 12 -р сарын 31 өдөр			
Код	Үзүүдэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1674455202	2654105788
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	422061202.1	1125859687
1200	Нийтлэг татварын бус орлого	422061202.1	1125859687
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1649300	
120004	Үндсэн үйл ажиллагааны орлого	1649300	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	163708806	24000000
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	256703096.1	1101859687
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1252394000	1528246100
1310	Улсын төсвөөс	777514400	989614500
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	777514400	989614500
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	474879600	610271762
131103	ЭГТХ, ЭДТХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хэсэг	230322700	269650100
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс дээд шатны төсвийн захирагчид хуваарилсан хэсэг	244556900	337724112
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд өнгө болсон нэмэлт орлого		2897550
1330	Төсвийн захирагчдаас		-71640161.68
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг		-71640161.68
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1494556709	1673974188
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1494556709	1673974188
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1448139417	1649636797
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	296934969	574445899.9
210101	Үндсэн цалин	247865778.3	447208112.4
210102	Нэмэгдэл	41593990.71	97078458.56
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	7475200	30159329
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74744820.65	78705280.36
210201	Тэтгэврийн даатгал	70217820.65	52532913.22
210202	Тэтгэмжийн даатгал	1131700	5729528.5
210203	ҮОМЦӨ-ний даатгал	905300	5477314.46
210204	Ажил үйлдлийн даатгал	226200	945451.26
210205	Эрүүл мэндийн даатгал	2263800	14020072.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9075051.39	7402970.36
210301	Гэрэл, цахилгаан	4598919.18	4827970.36
210302	Түлш, халаалт	4476132.21	175000
210304	Байрны түрээс		2400000
2104	Хангамж, бараа материалын зардал	57258969.34	40034642.03
210401	Бичиг хэрэг	6088325	6325980
210402	Тээвэр, шатахуун	18083703.2	23334026.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8429714.5	6918150
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	955027	3400336
210408	Бараа материал акласны зардал	23702199.64	56149.95
2105	Нормативт зардал	436874451.6	292523123.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	434562312.6	287384860.7
210502	Хоод, хүнс	2035239	5138263.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдгэл	276900	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9542790	3646700
210604	Урсгал засвар	9542790	3646700
2107	Томилголт, зочны зардал	2764600	17992300
210702	Дотоод албан томилголт	2764600	17992300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497455095.9	470503419
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495452895.9	458025990
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэгдэл тогтоох	450000	130929
210803	Даатгалын үйлчилгээ	778900	780000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	477300	520500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250000	246000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		10800000
210807	Газрын төлбөр	46000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63488669.6	164382461
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9522762	96314762.24
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	53965907.6	68067698.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46417291.51	24337391
2132	Бусад урсгал шилжүүлэг	32098758	19514764
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200000	
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30554808	18801960
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1343950	712804
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14318533.51	760907
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14180386.51	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	138147	760907
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4061720
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		4061720
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	179898493.2	980131600.1
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		360000.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		360000.04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гэрэ		360000.04
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI-III-IV-V)	179898493.2	979771600.1

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Өвөрхангай - Мал эмнэлэг (РД: 3565351)						
ЦЭВЭР ХОРОНГО/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН						
2021 оны 12 -р сарын 31 өдөр					<i>/тогтооноор/</i>	
Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл		31940481.55	456090079		488030560.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		31940481.55	456090079		488030560.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт					
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт					
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олд, гарз					
7	Өмчид гарсан өөрчлөлт			179898493.2		179898493.2
8	Зарласан ноогдол ашиг		31940481.55	635988572.2		667929053.7
9	Тайлант үеийн үр дүн					
10	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл					
11	2021 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл		31940481.55	635988572.2		667929053.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		31940481.55	635988572.2		667929053.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт					
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт					
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олд, гарз					
17	Өмчид гарсан өөрчлөлт					
18	Зарласан ноогдол ашиг					
19	Тайлант үеийн үр дүн			979771600.1		979771600.1
20	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл		31940481.55	1615760172		1647700654

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Өвөрхангай - Мал эмнэлэг

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1261236700.00	1535259516.32
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1649300.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1649300.00	0.00
120001	Хувьцааны ногдол ашиг		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1649300.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1649300.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1259587400.00	1535259516.32
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	777514400.00	989614500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	777514400.00	989614500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	482073000.00	617285178.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	230322700.00	276663516.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	244556900.00	337724112.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7193400.00	2897550.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	-71640161.68
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	-71640161.68

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1226731416.00	1493744380.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1226731416.00	1493744380.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1172320236.49	1473468709.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230685037.00	574515899.94
210101	Үндсэн цалин	158257091.74	447278112.38
210102	Нэмэгдэл	63376745.26	97078458.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9051200.00	30159329.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31153673.81	78700803.02
210201	Тэтгэврийн даатгал	22097477.33	52528435.88
210202	Тэтгэмжийн даатгал	2264098.62	5729528.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1811200.28	5477314.46
210204	Ажилгүйдлийн даатгал	452898.34	945451.26
210205	Эрүүл мэндийн даатгал	4527999.24	14020072.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12828919.18	21698170.36
210301	Гэрэл, цахилгаан	4598919.18	4827970.36
210302	Түлш, халаалт	8230000.00	14470200.00
210304	Байрны түрээс	0.00	2400000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39648765.50	37341116.00
210401	Бичиг хэрэг	7433800.00	6073380.00
210402	Тээвэр, шатахуун	16213900.00	15898020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8429714.50	6918150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7571351.00	8451566.00
2105	Нормативт зардал	225032200.00	246687410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	224350300.00	246306610.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	681900.00	380800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10010980.00	18570300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	614980.00	14794100.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4350000.00	0.00
210604	Урсгал засвар	5046000.00	3776200.00
2107	Томилолт, зочны зардал	2764600.00	17992300.00
210702	Дотоод албан томилолт	2764600.00	17992300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	620196061.00	477962710.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	618193861.00	465485281.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	130929.00
210803	Даатгалын үйлчилгээ	778900.00	780000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	477300.00	520500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250000.00	246000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	10800000.00
210807	Газрын төлбөр	46000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54411179.51	20275671.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33079230.00	19514764.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн	30554808.00	18801960.00

**Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	МӨНГӨН ТЭТГЭМЖ		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2324422.00	712804.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21331949.51	760907.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21331949.51	760907.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>34505284.00</u>	<u>41515136.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34505284.00	37453416.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34505284.00	37453416.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34505284.00	37453416.00
220001	Барилга байгууламж	12986584.00	37453416.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21518700.00	0.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-34505284.00</u>	<u>-37453416.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	4061720.00

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	777938500.00	764983313.49	989614500.00	917962338.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	777938500.00	764983313.49	989614500.00	917962338.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	735521300.00	731904083.49	969966300.00	898447574.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226399900.00	226399900.00	636915500.00	574515899.94
210101	Үндсэн цалин	151689800.00	153971954.74	477581000.00	447278112.38
210102	Нэмэгдэл	65248900.00	63376745.26	127995000.00	97078458.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9461200.00	9051200.00	31339500.00	30159329.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30564200.00	30564095.81	78746900.00	78700803.02
210201	Тэтгэврийн даатгал	21508000.00	21507899.33	52528600.00	52528435.88
210202	Тэтгэмжийн даатгал	2264100.00	2264098.62	5732200.00	5729528.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1811200.00	1811200.28	5508900.00	5477314.46
210204	Ажилгүйдлийн даатгал	452900.00	452898.34	954400.00	945451.26
210205	Эрүүл мэндийн даатгал	4528000.00	4527999.24	14022800.00	14020072.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14868900.00	14038919.18	24394700.00	21698170.36
210301	Гэрэл, цахилгаан	4632000.00	4598919.18	6439300.00	4827970.36
210302	Түлш, халаалт	9570300.00	9440000.00	14959400.00	14470200.00
210303	Цэвэр, бохир ус	660000.00	0.00	596000.00	0.00
210304	Байрны түрээс	6600.00	0.00	2400000.00	2400000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34653500.00	34348614.50	26966400.00	25394322.00
210401	Бичиг хэрэг	7642700.00	7504800.00	6582600.00	6073380.00
210402	Тээвэр, шатахуун	16213900.00	16213900.00	11414400.00	11255800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8589900.00	8429714.50	7301500.00	6918150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2207000.00	2200200.00	1667900.00	1146992.00
2105	Нормативт зардал	8970800.00	8895900.00	3707200.00	3351310.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8214000.00	8214000.00	3326400.00	2970510.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	756800.00	681900.00	380800.00	380800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18674100.00	18623480.00	4379300.00	4379300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10824100.00	10773480.00	4379300.00	4379300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4350000.00	4350000.00	0.00	0.00
210604	Урсгал засвар	3500000.00	3500000.00	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	293000.00	293000.00	534400.00	468000.00

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	293000.00	293000.00	534400.00	468000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	401096900.00	398740174.00	194321900.00	189939769.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397550400.00	396737974.00	181475400.00	177474340.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	450000.00	450000.00	130929.00
210803	Даатгалын үйлчилгээ	780000.00	778900.00	780000.00	780000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	520500.00	477300.00	520500.00	508500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250000.00	250000.00	250000.00	246000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1500000.00	0.00	10800000.00	10800000.00
210807	Газрын төлбөр	46000.00	46000.00	46000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42417200.00	33079230.00	19648200.00	19514764.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42417200.00	33079230.00	19648200.00	19514764.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	205000.0	200000.0	0.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39852800.0	30554808.0	18920700.00	18801960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2359400.0	2324422.0	727500.00	712804.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	777938500.00	763334013.49	989614500.00	989614500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	777938500.00	763334013.49	989614500.00	989614500.00
122005	Орон нутгийн төсвөөс	777938500.0	763334013.5	989614500.00	989614500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Өвөрхангай - Мал эмнэлэг		НТ-2	
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН			
/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	612462551.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	575009135.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	575009135.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	11946794.00
210402	Тээвэр, шатахуун	-	4.642.220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	7.304.574.00
2105	Нормативт зардал	0.00	243336100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	243.336.100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	14191000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10.414.800.00
210604	Урсгал засвар	-	3.776.200.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	17524300.00
210702	Дотоод албан томилолт	-	17.524.300.00

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	288010941.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	288.010.941.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	760907.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	760.907.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	37453416.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	37453416.00
220001	Барилга байгууламж	-	37.453.416.00
221001	Их засвар		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	617285178.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	617285178.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	276.663.516.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	337.724.112.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2.897.550.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор С.Шийлэгмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мал эмнэлгийн газар нь Мал эмнэлгийн газар нь Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавина.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,494.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 14.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 10.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 5.4 сая төгрөгөөр өссөн байгаа нь шинээр барилга байгууламж, автомашин, тоног төхөөрөмж худалдан авсан хэдийг ч хөрөнгө акталсан байна.
- Бараа материалын үлдэгдэлд материаллаг өөрчлөлт орсон, 981.4 сая төгрөгөөр өссөн.
- Өглөгийн дансанд оны эхэнд байсан үлдэгдэл болох НДШ-ийн өглөгийг барагдуулаагүй нийт өглөг 4.5 саяар өссөн байна.
- Урьд онд авлагын дансанд үлдэгдлээр тайлагнасан 7.01 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 1,535,259.5 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 1,497,806.1 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 989.6 сая төгрөгөөр батлагдаж, тодотголоор хянагдсанаар 917.9 сая төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 0.7 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Оны нийт төсвийн гүйцэтгэл 917.9 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Мал эмнэлгийн газрын нэмэлт санхүүжилт тайлант онд 617.3 сая төгрөг, тухайлбал:

- ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан -276.7 сая төгрөг,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвийн доод шатны төсвийн захирагчид хуваарилсан- 337.7 сая төгрөг
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого -2.9 сая төгрөг тус тус орж, зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдлөг болгоогүй, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4.4 сая төгрөгийн компьютер худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнээс бусад эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэхэд 2 горим сорилд алдаа зөрчил илэрч, 4 горим сорилд алдаа зөрчил илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мал эмнэлгийн газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 134 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага өгч хэрэгжилтийг хугацаанд нь 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4,389.6 мянган төгрөгийн компьютер худалдан авч зориулалт бусаар зарцуулсан.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс 380.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан байна.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мал эмнэлгийн газар	2	4.8					2	4.8		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

С.ШИЙЛЭГМАА

